



ХӨЛ ХОРИО БА ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ ЭРХ

Коронавируст халдварын цар тахлыг дэлхий нийтээрээ даван туулж буй энэ цаг үед Монгол Улс ч мөн хүнд сорилттой өдөр тутам тулгарч байна. Энэ цаг үед нөхцөл байдалд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, хүндрэл бэрхшээлийг хохирол багатай даван туулахад хувь нэмэр болох үүднээс үүсээд буй тохиолдлыг шинжлэх замаар гарц шийдлийг санал болгох ажлыг эхлүүлээд байгаа билээ. Халдварт өвчний дэгдэлтээс сэргийлэх

аливаа шийдвэр, үйл ажиллагаа хугацаа алдахгүй гарч байж үүдэн гарах хор хохирлыг бууруулах талтай ч энэ мэт богино шинжилгээнүүд тэдгээр шийдвэрийн чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд тустай хэмээн үзлээ. Энэ дугаарт цар тахалтай тэмцэх үйл ажиллагаа нь ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд хэрхэн нийцэж байгаад анхаарал хандуулахыг зорилоо.

НЭГ. ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хүн бүр арьс өнгө, нас, үндэс угсаа болон бусад байдлаар ялгаварлагдахгүйгээр хүн байх эрхээ эдлэх ёстой. Ковид-19 халдварын цар тахал гарсан энэ цаг үед хүний эрхийг зөрчсөн, бусдыг ялгаварлан гадуурхах үйлдэл гарч байна. Тухайлбал:

Нэг. Өөрийгөө тусгаарлаж буй иргэдийн гэрийн үүдэнд “Гэрийн тусгаарлалт” гэсэн тусгай тэмдэглэгээ бүхий хуудсыг наасан нь ялгаварлан гадуурхагдах нөхцөлийг бүрдүүлээ. Тус арга хэмжээг Дорнод аймгийн Баяндум, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Дархан-Уул аймгийн Зүүнбүрэн сумд болон Өвөрхангай аймагт хэрэгжүүлээд байна. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Мэргэжлийн хяналтын газар 14 хоног тусгаарлагдаж буй иргэдийн гэрийн үүдэнд тусгайлсан тэмдэглэгээ бүхий зурагт хуудас наасан

бөгөөд энэ үйлдлээ “тухайн тэмдэглэгээ нь айлд олноороо цуглах, тусгаарлалтын дэглэм зөрчих зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой”¹ хэмээн тайлбарлажээ.

Гэрийн хөл хорио нь нийгмийн харилцаанаас түр хугацаанд зай барих хэлбэр бөгөөд бие махбодын хувьд эрсдэлгүй орон зайд байхыг хэлж буй² юм. Харин олон нийтэд зарлах, тэмдэглэх зайлшгүй шаардлага бүхий нөхцөл биш. Энэхүү хуудсыг нааснаар өөрөө өөрийгөө тусгаарлаж буй иргэнийг бусад иргэд ялгаварлан гадуурхах, доромжлох, зүй бус харьцах, тэгш бус хандах нөхцөл үүсэх магадлалтай. Гэрийн хөл хорионд буй иргэд нь “Ковид-19” цар тахал туссан хэрэг биш, харин 14 хоногийн хугацаанд өөрөө өөрийгөө тусгаарлаж иргэний үүргээ биелүүлж буй хэлбэр юм.

¹ Өмнөговь аймгийн мэргэжлийн хяналтын газраас тус арга хэмжээний тухай тодруулсан мэдээлэл. <https://ikon.mn/n/227f> 2020 оны 12 дугаар сарын 5-ны өдөр. <https://gogo.mn/r/k56gl>

² Г.Агар-Эрдэнэ. Ковид-19 ба Ахмад настны эрх. Хүний эрх сэтгүүл: Онол, арга зүйн сэтгүүл. Улаанбаатар хот., 2020/№1, 8 дахь тал

Хоёр. Баянзүрх дүүрэгт нэг иргэн коронавирусын халдвар авсан нь тогтоогдож түүнийг хоёр хүүхдийн хамт тусгаарлах арга хэмжээ авсан. Тусгаарлалтын хугацаа дуусаж коронавирусын халдвар авсан иргэний хоёр хүүхэд гэртээ очих үед

байрны оршин суугчид болон Сууц өмчлөгчдийн холбооны зүгээс халдварын эрсдэлтэй гэж үзэж гэрт нь оруулаагүй зөрчил гарсан³. Иймээс хоёр хүүхдийг хүүхэд түр хамгаалах байранд түр хугацаанд байрлуулсан байна.

ХОЁР. АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.1 Ялгаварлан гадуурхахгүй байх төрийн үүрэг

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2 дугаар зүйлд “Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой.”⁴, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП)-ын 2 дугаар зүйлийн 2.1-д “Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй”⁵ хэмээн хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй байх үүргийг оролцогч улсад хүлээлгэсэн. Үүний зэрэгцээ Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн бусад олон гэрээ, конвенцид ялгаварлан гадуурхалтыг хориглсон билээ.⁶

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь тэгш байдал байх тухай, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.

Хүн бүр эрх зүйн этгээд байна” хэмээн тус тус заасан. Түүнчлэн хүний үндсэн эрхийг ямар ч ялгаварлан гадуурхалгүйгээр хүн бүрт эдлүүлэх ёстой, төр өөрөө ялгаварлан гадуурхах үйлдэл гаргаж болохгүй төдийгүй бусад хувь хүн, хуулийн этгээдээс үзүүлж буй ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоох үүрэгтэй.⁷

1.2. Хуульд заасан үндэслэл журмын дагуу гарсан байх

Өөрөө өөрийгөө тусгаарлаж буй иргэдийн гэрийн үүдэнд тусгайлсан тэмдэглэгээ бүхий зурагт хуудас наах нь хуульд заасан арга хэмжээ биш бөгөөд энэ нь ямар нэг эрх бүхий байгууллагын захирамж, шийдвэрээр баталгаажуулаагүй байна. Гамшгаас хамгаалах тухай хууль болон Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргах шийдвэр, арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу гарсан байх” шаардлагыг нэг мөр хангасан байхыг үүрэг болгосон.⁸ Өөрөөр хэлбэл, Хүний эрхийг хязгаарлахдаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэр, арга хэмжээ гаргах ёстой гэсэн үг. Гэтэл энэ шийдвэр албажаагүй, хуульд үндэслээгүй байна.

³ <https://ikon.mn/n/225n?fbclid=IwAR0weAyAdaK1sTGwEo46SV8UJpllxYEVBCoQ27JprcTyMxHgfedsobeOZWm>, 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдөр.

⁴ <https://www.legalinfo.mn/law/details/1271?lawid=1271>

⁵ <https://www.legalinfo.mn/law/details/1257?lawid=1257>

⁶ www.legalinfo.mn

⁷ О.Мөнхсайхан. Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт. 6 дахь тал. <https://legaldata.mn/buteel/pdf?id=783>

⁸ Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017 он, 10.9.1; Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, 2020 он, 11.1.1

1.3. Ялгаварлан гадуурхахгүй байх

Гамшгаас хамгаалах тухай хууль болон Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд ялгаварлан гадуурхахгүй, гутаан доромжлохгүй байх зарчмыг баримтална, Үндсэн хуулиар хамгаалсан иргэний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор болон бусад шинжээр нь ялгаварлан гадуурхахгүй, нэр төрийг нь доромжлохгүй байх шаардлагыг нэг мөр хангана хэмээн зохицуулсан.⁹

Гэтэл гэрийн хөл хорионд буй иргэдийн гэрийн үүдэнд коронавирусын халдварт өвчин туссан мэт тусгайлсан тэмдэглэгээ бүхий хуудас наасан нь гэрийн хорионд тусгаарлагдаж буй иргэний сэтгэл зүйд хүндээр тусаж байна. Түүнчлэн, гуравдагч этгээдийн зүгээс тусгайлсан тэмдэглэгээ бүхий хуудсыг харж тухайн иргэнийг коронавируст халдвартай гэдгээр ялгаварлах, нэр төрд нь халдах эрсдэлийг бий болгоно. Өөрөөр хэлбэл, гэрийн үүдэндээ тусгайлсан тэмдэглэгээ бүхий хуудас наалгасан иргэдийг хэсэг бүлэг хүмүүс “Аюултай, эрсдэлтэй хүн”, “Халдвар тээгч” гэж харах боломжтой.¹⁰ Иймээс тус шийдвэр, арга хэмжээ нь хүний эрхийг зөрчсөн гэж үзэж байна.

Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.21-д цар тахлын халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, ийм үйл ажиллагааг хуульд заасан аргаар таслан зогсоох арга хэмжээг Засгийн газар

авч хэрэгжүүлэх тухай заасан¹¹. Коронавируст халдварын цар тахал авсан иргэний хүүхдийг тухайн байрны СӨХ, иргэд ялгаварлан гадуурхсан. Төрийн зүгээс энэхүү ялгаварлан гадуурхах үйлдэл гарахаас өмнө урьдчилан сэргийлсэн арга хэмжээг авч ажиллах ёстой. Гэтэл манай улсын хувьд халдвар туссан иргэдийн гэрийг зааж, тодорхойлох тэмдэглэгээ наах, нийтэд ил болгох зэрэг арга хэмжээ авснаар дээрх ялгаварлан гадуурхагдах нөхцөл байдал үүсэж байна.

Түүнчлэн иргэдийн хувьд Үндсэн хуульд зааснаар¹² өөрийн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын эрхийг хүндэтгэх шаардлага үүсдэг. Иймээс хэн нэгнийг ялгаварлан гадуурхах, доромжлохгүй байх үүрэгтэй юм.

1.4. Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, нийгмийн эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон байх

“Ковид-19” цар тахлын үед хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ нь нийтийн эрүүл мэнд, хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгыг агуулах ёстой. Энэ нөхцөлд хязгаарлалт нь хүлээн зөвшөөрөгдөнө. Түүнчлэн хүний эрхийн хязгаарлалтын тухайн арга хэмжээ нь зорилгод хүрэхэд зайлшгүй бөгөөд тохирсон байхыг шаарддаг. Улаанбаатар хот болон бусад аймагт хөл хорионы хязгаарлалтад буй иргэдийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нутаг буцаах арга хэмжээг авч эхэлсэн. Энэ хүрээнд Шадар сайд 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “Зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулах түр журам” баталсан бөгөөд тус журамд заасны дагуу иргэн тухайн орон нутагт очмогц 14 хоногийн хугацаанд өөрийгөө гэртээ тусгаарлах ёстой.¹³ Улсын онцгой комисс гэрийн хөл хорионд орж буй иргэдийн гар утсанд аппликэйшн суулгах замаар дэглэмийг сахиж байгаа эсэхэд хяналт

⁹ Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017 он, 40.4.1; Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, 11.1.5

¹⁰ БНХАУ-д анх Коронавирус гарах үед Европод амьдарч буй иргэд ази хүмүүсийг өвчин тээгч, халдвартай хүн, эрсдэлтэй хүн гэж ялгаварлан харьцаж, хандаж байсантай адил нөхцөл байдал үүсэх аюултай гэж харж байна.

¹¹ Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, 2020 он, 7.1.21

¹² Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг.

¹³ Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Дугаар 146 тушаалын хавсралт “Зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулах түр журам”-ын 4.5, 6.7 дахь заалт.

тавихаар зохион байгуулсан.¹⁴ Үүнийг зарим аймаг нэвтрүүлэн, хэрэглэж байна. Тухайлбал, 2020 оны 12 дугаар сарын 5-ны байдлаар Орхон аймагт гэрийн ажиглалтад 753 иргэн байгаа¹⁵ бөгөөд тухайн иргэдийн гар утсанд GPSBOX байршил тогтоогчийг суулган хяналт тавьж байна.¹⁶

Гэтэл гэрийн хөл хорионд буй иргэний гэрийн үүдэнд тусгайлсан хуудас нааж буй нь зорилгодоо тохироогүй, зайлшгүй байх шинжийг хангаагүй, ялгаварлан гадуурхсан ноцтой зөрчил юм.

ГУРАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ



- Хөл хорионд буй иргэдийг ялгаварлан гадуурхахгүй байх, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр аливаа шийдвэр гаргахдаа Гамшгаас хамгаалах тухай болон Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах тухай хуулиудыг чанад баримтлах;
- Хууль, журамд заагаагүй шийтгэл, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх;
- Гэрийн тусгаарлалтад байгаа иргэний гэрийн гадаа тусгайлсан тэмдэглэгээ бүхий наалт нааж буй арга хэмжээг даруй таслан зогсоох;
- Төрийн зүгээс цар тахлын үед зорчих эрхийг хязгаарлахдаа олон аргыг нэг дор хэрэглэх бус аль сайн тохиромжтой, хүний эрхийг хамгийн бага хязгаарласан арга хэмжээг авах;
- Коронавирусын халдвар авсан, авсан байж болзошгүй иргэд болон гэр бүлийн гишүүдийн тухай бусдад мэдээлэхгүй байх, хувь хүний нууцыг чанд нууцлах.

¹⁴ Улсын онцгой комиссоос 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 36 дугаар хурлын тэмдэглэл.

¹⁵ <http://erdenet.mn/medee/d/201200011>

¹⁶ <http://erdenet.mn/medee/d/201200011>

